

## Наран толгойгоос шинээр илрүүлсэн руни бичгийн дурсгал

Цэндийн Баттулга<sup>1,\*</sup>, Дамчаабадгарын Содномжамц<sup>2</sup>, Төмөрбаатарын Түвшинжаргал<sup>2</sup>

**Товч агуулга:** Сүүлийн жилүүдэд Монголын руни бичгийн дурсгалын бүртгэл харьцангуй бүрэн болж судалгаа улам нарийсан гүнзгийрч байгаа ч жилээс жилд нэмэгдэж, шинээр илэрч олдсоор байна. Энэ удаад бид Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Наран толгойгоос шинээр илрүүлсэн 10 хэсэг руни бичгийн дурсгалыг шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор урьдчилсан судалгааны үр дүнг нийтлүүлэв. Бичээсүүд тэнгэрт хальсан эгчийнхээ уй гашууд зориулсан, зарлиг тушаал сонссон, зам өртөө байгуулсан, ариун шүтээнт газар, усаа дурдсан, өлзийтэй байхыг ерөөсөн зэрэг утга агуулгатай бөгөөд Уйгурын хаант улсын үед “тугч ард иргэд” хэмээн нэрлэдэг төр, цэргийн нэгж байсныг илтгэх шинэ мэдээ буй нь түүхийн судалгаанд ач холбогдолтой чухал сурвалж болж байна. Үсэг бичгийн тиг хэлбэр, үгийн санд тулгуурлан эдгээр бичээсийг Уйгурын хаант улс (744-840) -ын эхэн, дунд үед холбогдоно хэмээн үзэж байна.

**Түлхүүр үг:** Өвөрхангай аймаг, Есөнзүйл сум, Наран толгой, Уйгур улс, руни бичиг, тамга

### Удиртгал

Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын нэгдүгээр багийн нутаг Зүйлийн хөндийд орших сондгой ганц уулыг нутгийн ардууд Наран толгой хэмээн нэрлэдэг. Судалгааны тоймоос үзвэл түүх соёлын дурсгал сонирхогч, барилгачин н.Дэмчигжав анх Есөнзүйл сумын Наран толгойн хадны зураг дахь 50 орчим тамга тэмдэг, 5 амьтны тойм дүрсийг гараар хуулбарлан зурж, нэрт эрдэмтэн Х.Пэрлээд ирүүлснийг 1977 онд тэмдэглэл хэлбэрээр зургуудыг хавсарган нийтэлсэн байдаг (2012: 191-194). Түүнээс хойш Наран толгойн дурсгал судлаачдын сонорт хүрч, сонирхон судлах эхлэл тавигджээ. Хожим археологич Т.Санжмятав Наран толгойн хадны зургийг үзэж, цөөн дүрсийг тодорхойлон судалж, гар зургийн хамт хэвлүүлжээ (1995: 38-39, табл. 112-114).

Наран толгойн дурсгал нь хадны зургаас гадна уулын бэл орчмоор булш оршуулгын дурсгал элбэгтэй. МЗТСХЭ-ийн хүрээнд 1978-1983 оны орчимд Наран толгойд дөрвөлжин булш малтсан мэдээ бий (Сэр-Оджав 1987: 10) бол 1991 онд археологич Д.Наваан Наран толгой болон түүний ойролцоох Барзан ууланд хүннү булш малтан судалж, улмаар энэхүү дурсгалт газарт дөрөв дэх удаагаа ирж буйгаа дурдаад энэ орчимд цаашид суурин судалгаа явуулах боломжтой хэмээн дүгнэсэн байдаг (1991: 5).

Наран толгойн хадны зургийг нарийвчлан судлах зорилгоор 2024 оны 10-р сарын 17-нд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид тус газарт очиж нийт 424 хавтан чулуун дээрх хадны зургийг бүртгэн баримтжуулж, руни бичгийн хоёр дурсгал илрүүлсэн билээ. Шинээр илрүүлсэн хоёр руни бичээсийг эх бичгийн үүднээс судлах, нягтлан магадлах зорилгоор зохиогчид Наран толгойд дахин очиж хээрийн судалгааны ажил хийсний үр дүнд нэгээс дөрвөн мөрөөс бүтэх нийт арван хэсэг бичээс буйг илрүүлж судалгааны эргэлтэд оруулж байна.

Наран толгой хэмээх уул нь бор хүрэн өнгийн хүрмэн чулуун тогтоцтой ба толгойн энгэр бэл хэсгээр хүрлийн үеийн шоргоолжин булш, Сагсай булш, хиргисүүр, дөрвөлжин булштай бол уулын ар, орой, энгэр хэсгийн дэл хаданд олон тооны хадны зургийн дурсгалтай. Үүнээс гадна энд онцгойлон өгүүлж буй орой болон энгэрийн хад чулуунд сийлсэн бичээсүүд нь руни бичгийн судлалд нэгэн шинэ сурвалж болж буйгаараа ихээхэн ач холбогдолтой юм.

Өмнө нь Монгол улсын баруун бүс нутгаас Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутагт орших Хар Ааргийн Бичигт хадны өвөлжөөнд долоон хэсэг, харин зүүн болон өмнөд бүс нутгаас Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын таван хэсэг бичээс буй нь нэг дороос илрүүлсэн хамгийн олон дурсгалд тооцогдож байв. Харин Монголын төвийн бүс нутгаас руни бичээсийн зураасан бичгийн төрөлд багтах ийм олон бичээс нэг дор илэрч байсангүй билээ.

Наран толгойд руни бичгээс гадна Хүннү болон Түрэг, Уйгурын үед холбогдох тамга, нэгжээд монгол,

<sup>1</sup> МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Ази судлалын тэнхим

<sup>2</sup> ШУА-ийн Археологийн хүрээлэн

\* Холбоо барих зохиогч: [tulga@num.edu.mn](mailto:tulga@num.edu.mn)  
<https://orcid.org/0000-0002-3551-0399>

төвд бичээс буйг дурдъя. Монгол, төвд бичээс он цагийн хувьд нэлээд хожуу XVIII-XIX зууны үед холбогдох бололтой ба түүнээс ч хожуу бичсэн бичээс бас байна. Мөн 1970, 1980-аад оны үед кирилл үсгээр ихэвчлэн бичсэн, эрээчсэн зүйл цөөнгүй байх ажээ. Ер нь Наран толгойд хаданд эрт үед холбогдох босоо, хэвтээ зураас, зурлага, сараачмал зураас элбэг байх бөгөөд тэдгээрийг чухам ямар утга учиртайг тодруулан судлуулж тэмдэглэх нь зүйтэй.

Наран толгойн руни бичгийн дурсгалууд байршлын хувьд энд тэнд, хэмжээний хувьд харилцан адилгүйгээс гадна тодорхой байрлал, дараалалгүй бичсэн байх тул баруун энгэрийн бичээсийг нэгдүгээр бичээс гэж болзмолоор нэрлэв. Өөрөөр хэлбэл, бичээсийг дугаарлахдаа толгойн баруун энгэрээс орой хүртэл, толгойн оройгоос зүүн, өмнө тал гэсэн чиглэлтэйгээр дугаарласан болно (Зураг 1).

Хад чулуун дээрх эртний бичгийн дурсгал судлалд, ялангуяа руни бичгийн судалгаанд үсэг тэмдэгт нэг бүрийг алдаа мадаггүй буулгах нь туйлаас чухал байдаг. Бичээсийн үсэг тэмдэгт бүрийг зөв буулгаснаар түүхэн чухал сурвалж болох бичээсийг эхнээс нь зөв тайлж унших, улмаар үнэн бодит мэдээллийг шинжлэх ухааны эргэлтэд оруулах, олон нийтэд зөв мэдээ, мэдээлэл хүргэх зэрэг олон талын ач холбогдолтой билээ. Наран толгой хэмээх багахан толгойд хоёр өдөр ажилласан эх бичгийн судалгааны ажлын үр дүнд бичээс бүрийн үсэг тэмдэгтийг мадаггүй, үнэн зөв буулгасан гэдэгтээ итгэлтэй байна.

### Нэгдүгээр бичээс

Наран толгойн баруун энгэрт 46 см өргөн, 83 см урт хэвтээ хаданд нэг мөр бичээсийг хурц үзүүртэй

багажаар зурж бичжээ. Найман үсэг тэмдэгт, уг тусгаарласан нэг хос зураас бүхий уг бичээсийн үсгийн өндөр 2.5-3 см, мөрийн урт 3 см. Бичээст шууд холбогдох дөрвөн тамгатай. Үүнээс бичээсийн дээд талд хадны өнгөн хэсгийг холцруулан цохих аргаар Басмил овог аймгийн тамгыг томоор, бичээсийн зүүн талд Карлук аймгийн тамгатай төстэй тамгыг харьцангуй жижгээр дүрсэлсэн нь нарны тусгалаас хамаарч тод, бүдэг харагдах ажээ (Зураг 2).

Бичээсийг гүнзгий сийлсэн тул маш тод ба бичээс хэв, дардас авахад ч боломжийн тодорхой харагдаж байв.

### Хүснэгт 1. Наран толгойн I бичээсийн уншлага



|                    |                              |
|--------------------|------------------------------|
| Эхийн сийрүүлэг:   | »ЧН»:ҺСН᠑                    |
| Үсгийн галиг:      | у ü г t: W Q R m             |
| Үгийн галиг:       | yügät uqarīm                 |
| Үгчилсэн орчуулга: | Хуралдаан.<br>Ухааруулна би. |

Бичээсийн хоёр үгийг тус тусад авч үзье.

ҺСН᠑ yügät (~yügüt). Эртний Түрэг, Уйгур хэлний yüg- хуралдаан-, цуглаан уул- гэх утга бүхий нэр язгуурт нэрээс нэр үг бүтээх +t[i] дагавар залгаж yügäti (~ yügüti) - бүгд, цуг, бүгдийг нь, цугийг нь гэсэн утгатай нэр үг бүтээжээ.

»ЧН» uqarīm (uqurīm). uq- ух-, мэд-, ойлго- үйл язгуурт үйлээс үг үйл бүтээх -г дагавар залгаж, улмаар нэгдүгээр биед хамаатуулан төгсгөжээ.

Энэхүү ганц мөр, хоёр үгээс бүтэх бичээсийн үсэг тэмдэгт нэн тодорхой боловч утга агуулга нь бүрхэгдүү юм. Учир нь өөрийн харьяаны ард иргэд, албатаа ухааруулж сэнхрүүлэхээр шийдсэн үү, эсвэл




Зураг 1. Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Наран толгойн дурсгалт газар болон бичээсийн байршил

өөр овог аймгийг ухааруулан нэгтгэхээ илэрхийлж бичсэн үү гэдэг нь эргэлзээтэй. Басмил аймгийн тамганы гурван хувилбар байгаагаас үзэхэд, Басмил аймгийн эрх мэдэлтэн бичсэн, бас Басмил аймгийн ард иргэдийг ухааруулахаа илэрхийлсэн байж болох юм.

## Хоёрдугаар бичээс

Нэгдүгээр бичээсийн баруун дээд талд, хадны баруун хойш харсан толигорт нэг мөр бичээсийг хурц үзүүртэй багажаар тун гаргацтай сийлжээ. Бичээс шууд болон дам холбогдох тамгагүй. Хадны баруун хойш харсан байдал нь тавтай сууж бичээсийг бичихэд тохиромжтой, эвтэйхэн байрлал ажээ. Үсэг тэмдэгтийн өндөр 5-8 см, мөрийн үрт 65 см (Зураг 3).



Зураг 2. Нэгдүгээр бичээс

*Хүснэгт 2. Наран толгойн II бичээсийн уншлага*

Эхийн сийрүүлгэ: ᠯᠢᠭᠡᠨ ᠶ᠋ᠣᠵᠤᠰᠦᠳᠦᠷᠪᠦᠩᠬᠡᠲᠦᠨᠠᠭ᠎ᠠ

Үсгийн галиг: (W) L G k t η r k n k a k i y i: y k ü š  
r t k a

Үгийн галиг: ulуу äk tänrikänkä kiyi: yäkü äširtkä

Үгчилсэн орчуулга:Хуралдаан. Ухааруулна би.

Утгачилсан орчуулга: Том эгч тэнгэр болоочид  
энэлсэн их үй гашуудалд

Бичээсийн утга агуулгыг илүү тодорхой болгох үүднээс эхний гурван үгийн тухайд тухайлан өгүүлье.

ᠶ᠋ᣳ(ᠥ) uluy их, том гэх утгатай үг. Хоёрдугаар бичээсийн эхний ᠶ᠋ᣳ(ᠥ) uluy гэх үгийн эхний ᠶ u үсэг ихэд балархайшиж нар, гэрлийн тусгалыг эс ашиглаваас мэдэгдэхээргүй бүдгэрсэн учир дугуй () хаалтад бичив.

ᠶ ᠠᠭ эх, толгой гэсэн утгатай үг. Бичээсийн эхийг баримталбал ийн уншиж болох бөгөөд Монголын руни бичгийн дурсгалуудаас зөвхөн Туньюкуын гэрэлт хөшөөний бичээст нэг л удаа тохиолдоно. Үүнд:

[illegible]

**уулыг** өнгөрч Төмөр хаалга хүртэл ирэв бид. (Тун. мөр: 44-45) гэснээс үзэхэд эртний түрэг хэлний **ᠶ** äk гэх үгийн утга маш тодорхой байна. Эртний энэ үг ойрад аман аялгуунд эк толгой, түрүү гэсэн үндсэн язгуур утгаараа одоо ч идэвхтэй хэрэглэгдсээр байгаа билээ. Жишээ нь: эк эргэх - толгой эргэх, экин эргэж - толгой нь эргэж гэх мэт.

Монголын руни бичгийн бага дурсгалын сонгодог дурсгалуудаас ялгарах нэг гол онцлог нь зарим тохиолдолд үсэг зүй, хэл зүйн дүрэм зөрчиж эр (хатуу), эм (зөөлөн) гийгүүлэгчийн хольж бичих, эгшиг орхигдуулж бичих нь бий. Мөн бичээчийн хэл аялгууны тусгал бүхий үгс цөөнгүй тохиолддог.

Эртний бичгийг тайлж уншихад эхийг баримтлах нь туйлын чухал боловч руни бичгийн бага дурсгалын тухайд, зарим тохиолдолд дээр дурдсан мэт эгшиг бичилгүй хураангуйлах нь буй тул тухайн бичээсийн агуулгыг харгалзан үзэх зайлшгүй шаардлага тулгардаг.

Тус бичээсийн агуулгаас үзэхэд **ᠠ** āk толгой, эх, түрүү гэх үг бус харин **ᠠᠠ** ākā эгч хэмээх үгийн төгсгөлийн а а эгшгийг бичээгүй бололтой байна.

Энэ мэт тохиолдол цөөнгүй бөгөөд тухайлбал,  
Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт орших  
Шанаган хэвийн хоёрдугаар хөшөөний бичээст  
**ᠶᠡᠭᠴᠢᠨᠠᠳᠤᠯᠤᠰ** äkä urī bilig ayıqmadı – эгч, нуган  
мэдээ хэлсэнгүй буюу утгачилж буулгавал эгч (эх?),

нуган (хоёр) тангараг няцсангүй гэсэн бичээст ʎ āk гэх үгийг дан ганц ʎ k гийгүүлэгчээр тэмдэглэсэн бий (Баттулга 2022: 165).

ᠠᠭᠤᠷᠲᠠᠨ tāᠩᠭᠢᠵᠠᠨ тэнгэрхэн. Язгууртан ихсийн тэнгэр хальсан, тэнгэр болсныг заасан, эртний цээрлэх ёс, зан үйлийн үг хэллэг хэмээн үзсэн билээ (Баттулга 2022: 151).

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын нутагт орших Ар Ханангийн бичээст **ᠠᠷᠬᠠᠨᠠᠩᠭᠡᠨᠠᠷᠭᠠᠨ** *tänrikän qunčuy yigän* тэнгэрхэн гүнжийн зээ хэмээн тэмдэглэсэн нь гүнжийг тэнгэрхэнд өргөмжилсөн хэрэг огт биш, харин тэнгэрт хальсан гүнжийн зээгийн тухай өгүүлж буй хэрэг юм. Нөгөө талаар,




Зураг 3. Хоёрдугаар бичээс

Үүний учир **ᠲᠠᠩᠷᠢᠭᠠᠨ** tāṅrikān гэж өргөмж цолыг хатад, гүнж нарт олгосон байх боломжгүй. Хэрвээ олгодог байсан бол Ил Тириш хааны хатан Ил Билгэ хатныг **ᠲᠠᠩᠷᠢᠭᠠᠨ** tāṅrikān гэж өргөмжлөх байсан нь лавтай. Тиймээс тэнгэр болсон, тэнгэрт хальсан, тэнгэр болооч язгууртныг **ᠲᠠᠩᠷᠢᠭᠠᠨ** tāṅrikān гэдэг байжээ гэж үзэх үндэстэй. Үүний учир **ᠲᠠᠩᠷᠢᠭᠠᠨᠠᠨᠢᠯᠢ** (**ᠲ**) uluṅ āk tāṅrikānkā гэх өгүүлбэрийг “Том эгч тэнгэр болоочдоо” буюу нас барсан том эгчдээ гэсэн утгатай хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл, бичээсийг том эгч нь тэнгэрт хальсан энэлэл их уй гашууд зориулж эрх мэдэлт, язгууртан дүү нь бичиж үлдээсэн боловч өөрийн нэр, цолыг дурдаагүй байна.

## Гуравдугаар бичээс

Наран толгойн овооны баруун талд, толгойн оройд ирмэглэж тогтсон, 57 см урт, 62 см өргөн цайвар шаргал хаданд хоёр мөр бичээсийг хурц үзүүртэй багажаар бичжээ. Нэгдүгээр бичээсийн үсгийн өндөр 2.7 см, мөрийн урт 137 см, хоёрдугаар бичээсийн үсгийн өндөр 2 см, мөрийн урт 20 см. Бичээсийн нэг, хоёрдугаар мөрийн хоорондох зай 15 см. Бичээс шууд болон дам холбогдох тамгагүй. Уг хаданд бичээс бичихээс өмнө болон хойно зурсан олон сараачмал

нүүдэлчдийн эртний тэнгэр шүтлэгт соёл сэтгэлгээний үүднээс авч үзвэл гүнж, хатад болон ер эмэгтэй хүнийг эцэг тэнгэртэй эн тэнцүүлэх, эцэг тэнгэрийн нэрийг дурдсан цол, өргөмжлөлөөр өргөмжлөх ёс уламжлал байх боломжгүй юм. Туньюкукын гэрэлт хөшөөний 38-р мөрд **ᠳᠠᠵᠢᠢᠠᠭᠣᠯᠠ** tānᠭi umay тэнгэр, умай (Эцэг тэнгэр, эх умай) гэж, мөн түүнчлэн Күл тигиний гэрэлт хөшөөний зүүн талын 31-р мөрд **ᠲᠤᠭᠤᠨᠠᠭᠣᠯᠠᠭᠣᠳᠤᠨᠠᠭᠤᠨ** umay ātäg ögüm qatun qutīṇa -Умай ивээлт эх хатны өлзий хишиг (хутаг)-ээр хэмээн тэмдэглэснээс үзэхэд Түрэгийн үед **ᠳᠠᠵᠢᠢᠠᠭᠣᠯᠠ** tānᠭi umay ‘эцэг тэнгэр, эх умай’ гэдэг ойлголт, ухагдахуун нэгэнт хэвшиж тогтсон байсныг илтгэнэ.



зураастай тул бичээсийн төгсгөл орчмын үсэг тэмдэгтийг сайн эс нягталбаас зөв таньж уншихад бэрх болжээ. Тус бичээсийн эхний нэг үсэг нэлээд балархайшсан боловч нийт үсэг тэмдэгт маш тодорхой харагдаж байна. Ялангуяа хоёрдугаар мөрийн үсэг тэмдэгт нэн тодорхой. Тус бичээс анх илрүүлсэн хоёр бичээсийн нэг мөн болно (Зураг 4).

*Хүснэгт 3. Наран толгойн III бичээсийн уншлага*

### Эхийн сийрүүлгэ:

[illegible]

2.  $\times \rightarrow \downarrow$

Үсгийн галиг:

1.ONYTidsiOWTLGBWLniDuOvršWb

2. TW LuQ p a b n b i t i d m

Үгийн галиг:

1. qan yat[t]i ädisi: qutluy boluñ iduq yär şub

2. tuluq apa bän bitidim

Үгчилсэн орчуулга:

1. Хан хүндлэл үзүүлэв. Эзэн нь өлзийтэй болог!

Ариун газар ус


2. Түлүк апа би, бичив би.

Утгачилсан орчуулга: Хан хүндэтгэж тахив. Эзэн нь өлзийтэй болог! Ариун газар ус. Тулук апа бичив би.

Бичээсийн мэдээнээс үзвэл, Уйгур улсын үед аль нэг овог аймгийн хан, ихэс язгууртан, захирагч, ноён Нар толгойг тахисан түүхэн үйл явдал болсон, тус тахилгад биечлэн оролцсон шадар туслах нь Тулук нэрт апа цолт нэгэн уг үйл явдлыг хаданд бичиж мөнхлөн үлдээсэн нь илэрхий байна. Мөн түүнчлэн газрын эзэн гэдэг ойлголт тэр үед нэгэнт тогтсон байсныг, газрын эзэд хийгээд ариун, шүтээнт газар, усыг тахиx тахилга хийдэг байсныг, өдгөөх нутгийн зон олны их шүтээнт Наран хайрхныг Уйгурын үед лавтай тахиж байсныг бичээсийн агуулгаас мэдэж болох юм. Уйгур улсын үеийн тэнгэр, газрын шүтлэгт холбогдох түүхэн баримт, бичгийн сурвалж болж буйд дээрх хоёр мөр бичээсийн түүхэн ач холбогдол, үнэ цэн оршиж байна.

### Дөрөвдүгээр бичээс

Нар толгойн овооны баруун өмнө талд, дундуураа хагарсан 135 см өндөр, 45 см урт, 40 см өргөн гүн бор хүрэн өнгөтэй, ургаа хадны том хагархайн доод талд, нарийн хагархайн дээр, доор хоёр мөр бичээсийг хурц



Зураг 4. Гуравдугаар бичээс

үзүүртэй багажаар гаргацтай, нарийн нягт сийлжээ. Хоёр мөр бичээсийн хооронд Х тэмдэг байх бөгөөд энэ нь бичээст шууд холбогдох тамга уу, эсвэл хоёр мөрийг тусгаарласан болзмол тэмдэг үү гэдэг нь нэн эргэлзээтэй. Улаан чулуут зэрэг цөөн хэдэн газрын бичээст мөн Х тэмдэг байх бөгөөд ихэвчлэн тойруулж дугуйрсан, эсвэл хад чулууны хоёр талд эсэргүүцүүлж бичээст тохиолдох нь бий. Тиймээс бид бичээс үргэлжилж буйг заасан тэмдэг гэж үзсэн билээ. Тус бичээсийн хувьд хоёр мөрийн дунд байх тул хоёр өөр бичээс бус, хоёр мөрөөс бүтсэн нэг бичээс болохыг илэрхийлсэн болов уу хэмээн таамаглаж байна.

Үсгийн тиг, хэмжээ жигд, маш тод, нарийн нягт бичсэнээс харахад бичээч тун чадварлаг, дадлага туршлагатай нэгэн байсан бололтой.

Бичээсийн нэгдүгээр мөрийн үсгийн өндөр 3.5-4 см, мөрийн урт 18 см, мөр хоорондын зай 10 см.

Хоёрдугаар мөрийн үсгийн өндөр 2.5-3 см, мөрийн урт 10 см. Бичээст шууд болон дам холбогдох тамгагүй (Зураг 5).

### Хүснэгт 4. Наран толгойн IV бичээсийн уншлага

Эхийн сийрүүлэг:

ᠶᠰᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨᠶᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ .1

ᠶᠰᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨᠶᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ .2

Үсгийн галиг:

1. T W G č i B W D N η b η l g č B š

2. š m N: l t m s č k m s

Үгийн галиг:

1. tuγčī bodunñ bāñlig čabīš


2. šaman ālātmiš āčākmiš (~ičikmiš)

Үгчилсэн орчуулга:

1. Тугч ард зоны байнгын захирагч

2. Шаман цэрэглэжээ, эзэлжээ.

ᠶᠰᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ tuγčī bodun тугч ард иргэд, ард зон. Тус бичээсийн үсгийн тиг хэлбэр нь Уйгурын үеийн дурсгал болохыг баттай илтгэж байна. Бичгийн



дурсгалын ерөнхий он цаг нэгэнт тодорхой тул, Уйгурын хаант улсын үед улс, аймгийн болон их цэргийн тугийг сахих, хамгаалах үүрэг бүхий ард иргэдийг тусгайлан зохион байгуулж тэднийг ᠶᠰᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ tuγčī bodun тугч ард иргэд, ард зон гэж нэрлэж байсан бололтой.

Түрэгийн үед холбогдох руни бичгийн сонгодог болон бага дурсгалуудад ᠶᠱᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ туγ гэх үг тохиолдохгүй бөгөөд харин Уйгурын хаант улсын үеийн дурсгалд ᠶᠱᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ tuγ, ᠶᠱᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ tuγluγ, ᠶᠱᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ tuγčī гэх үгс цөөнгүй тэмдэглэгджээ. Жишээ нь, Могойн шинэ усны буюу Моюн чурын гэрэлт хөшөөнд :ᠠᠨᠶᠢᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨᠶᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ :ᠶᠱᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ tuγ tašiqir ārkli yālma āri kälti – Туг мандуулж бүхүйд сэргийлэх цэрэг ирэв (зүүн, мөр:5-6); :ᠶᠱᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨᠶᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ üč tuγluγ türük bodun – ... гурван тугт Түрэг ард иргэд (хойд, мөр: 8; баруун, мөр: 7-8) гэж тус тус тэмдэглэсэн нь

Уйгурууд тугийг чухалчилж, тугаар баримжаалж байсны нэг илрэл хэмээн үзэж болох юм.

Мөн он цагийн хувьд, Уйгур улсын үед холбогдох Тэвшийн бичээст **TUGČI BOLTIM ÄSID[IN] 2. TUGČI BURGUČI YAGİZ ĆUR TUGRAGİ - 1.** Тугч болов би. Сонсогтун. 2. Тугч бүрээч Ягыз чурын тамга (Баттулга 2022: 190-192) гэж тэмдэглэсэн байдаг. Уг бичээсийг Өвөрхангай аймгийн Богд сум, хуучнаар Ховд сумын Тэвш уулын хадны зураг дурсгалыг тусгайлан судлах явцдаа 1949 онд А.П.Окладников (1980) илрүүлж, Б.Ринчен 1968 онд бичээсийн гэрэл зургийг хэвлүүлснээр шинжлэх ухааны эргэлтэд орсон (1968: 43) бөгөөд Н.Сэр-Оджав (1977: 141), В.М.Наделяев (1974: 136-150), С.Харжаубай (1979: 33), Л.Болд (1990: 110-112) нарын зэрэг эрдэмтдийн судалгаа бий. Дээрх бичээсийн агуулгаас тухайн үед “тугч болох” нь нэр



Зураг 5. Дөрөвдүгээр бичээс

ᠶᠰ᠕ čabīš захирагч, ерөнхий захирагч, өрлөг захирагч (жанжин).

Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудаас Туныюкукын гэрэлт хөшөөнд: ᠳᠡᠬᠡᠨᠢᠭᠦᠰᠡᠨᠲᠤᠨᠢᠯᠭ᠎ᠠᠵᠢᠶ᠋ᠠᠨ билгәси: čabiši: bān ük(ök) ārtim – [Ил тириш хааны] [төрийн] зөвлөх нь, [цэргийн] захирагч нь би л байв (мөр: 7); Күли чурын гэрэлт хөшөөнд ᠬᠦᠯᠢᠴᠣᠷᠠᠨᠠᠨᠴᠠᠭᠤᠨᠪᠢᠯᠭ᠎ᠠᠵᠢᠶ᠋ᠠᠨ билгәси küli čur: ančaq: bilgäsi čabiši ārti alpī bōkāsi ārti - Күли чур тийм [төрийн] зөвлөх нь, [цэргийн] захирагч нь байв. Баатар зоригтой нь, бөх чадалтай нь байв (мөр: 17) хэмээн түс түс тэмдэглэгдсэн байдаг.

Энэ үг утга, гарлын хувьд, эртний Түрэг хэлний дурсгалуудад тэмдэглэгдсэн *čab* (~*čav*) цуу, *kü čav* алдар цуу, *čav suruγ* цуу сураг, монгол бичгийн дурсгалд *aldar čab* (Cleaves 1955: 221-234) гэх үгстэй холбогдоно.

**ԿՏԼԵ ՄԱՀՎԱՅՈՒՆ**» ՆՍԻՂԸ **tuyçi bodunin bänlig çabiš**

хүндтэй чухал алба болох нь лавтай байна.

Энэ далимд тэмдэглэхэд, Тэвш (Тэгшийн улаан) уулаас 2023 оны 10-р сард хоорондоо тав орчим км зайтай хоёр өөр газраас руни бичгийн дурсгал шинээр илрүүлсэн (Баттулга 2024: 109-115) бөгөөд Тэвш (Тэгшийн улаан) уулаас илэрсэн руни бичгийн бүх дурсгалыг нэгтгэж судалгааны өгүүлэл нийтлүүлсэн билээ (Баттулга, Буюн-Орших 2024: 168-174).

ᠳᠤᠭᠴᠢᠨᠲᠣᠩᠭᠡᠳᠦ᠋ᠭᠦᠨ тугч bodun тугч ард иргэд, ард зон гэж тусгайлан зохион байгуулсан, тухайн үеийн төр, цэргийн чухал нэгж байжээ.

ᠢᠶᠤᠨ бэлгиг байнгын, үргэлжийн. Хоёрдугаар бичээст холбогдуулан Туньюкукын гэрэлт хөшөөнд Тэнгэр уулыг ᠢᠶᠤᠨ бэлгиг мөнх, мөнхөд эх тэргүүнт гэдэг болохыг өгүүлсэн билээ. Харин энэ бичээст ᠢᠶᠤᠨ бэлгиг гэх үгийг байнгын, үргэлжийн гэсэн утгаар сонгон бичсэн бололтой.



- Тугч ард зоны байнгын захирагч гэж бичсэн нь Тугч ард иргэдийг зохион байгуулсан тэр үеэс эхэлж тасралтгүй захирч байсан, одоо ч захирсаар байгаа захирагч мөн болохыг илэрхийлж буй бололтой.

**ᠰᠠᠮᠠᠨ** saman (~aşaman) älätmiš äčäkmiš (~ičikmiš) - Шаман (~Ашман) цэрэглэжээ, эзэлжээ гэснээс үзэхэд, Шаман (~Ашман) гэдэг нь тугч ард иргэдийн захирагчийн нэр мөн байна. Тус бичээсийг Тугч ард иргэдийг олон жил захирсан Шаман нэрт захирагч (жанжин)-ийн байгуулсан алдар гавьяа, зүтгэлийг бичиж тэмдэглэн мөнхжүүлэх үүднээс уг бичээсийг бичсэн бололтой. Бичээсийг тугч зоны захирагч Шаманы дурдатгаснаар бичихдээ бичээч нэрээ дурдаагүйгээс гадна бичүүлэгч, бичээчийн аль алиных нь овгийн тамга сийлэхийг чухалчилсангүй ажээ.

Уйгурын хаант улсын үед тугч ард иргэд, тугч ард зон, тугч зон гэж нэрлэдэг төр, цэргийн нэгж байсныг бичээс баталж байна. Энэхүү бичээс хоёр мөр боловч

түүхийн судалгаанд чухал ач холбогдолтой шинэ мэдээг агуулсан сурвалж мөн болно.

### Тавдугаар бичээс

Наран толгойн овооны баруун өмнө талд, цайвар бор шаргал өнгөтэй 40 см × 45 см хавтгай хадан дээр дөрвөн мөр бичээсийг хурц үзүүртэй багажаар тун тодорхой сийлж бичсэн байна.

Бичээсийн нэгдүгээр мөрийн урт 20 см, үсгийн өндөр 5 см, хоёрдугаар мөрийн урт 20 см, үсгийн өндөр 5 см, гуравдугаар мөрийн урт 20 см, үсгийн өндөр 4 - 5 см, дөрөвдүгээр мөрийн урт 31 см, үсгийн өндөр 7 см.

Бичээсийн эхний хоёр мөрийг хадны зүүн ирмэгээс эхлэн бичсэн байх ба үргэлжлүүлэн бичих боломжгүй болсон тул гуравдугаар мөрийг бичээсийн дээд талд, дээрээс баруун доош чиглэлтэй, дөрөвдүгээр мөрийг нэгдүгээр мөрөөс багахан зайтай, зүүнээс баруун доош чиглэлтэйгээр тус тус бичсэн байна.

Гуравдугаар мөрийн хоёрдугаар үгийн төгсгөлийн хоёр үсэг тэмдэг их балархайшиж ул мөр төдий болжээ. Тиймээс бид тус хоёр үсэг тэмдэгийг дугуй () хаалтад бичив (Зураг 6).

#### Хүснэгт 5. Наран толгойн V бичээсийн уншлага

Эхийн сийрүүлэг:

ᠠᠶᠠᠴᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠨ  
ᠠᠶᠠᠴᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠨ  
ᠠᠶᠠᠴᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠨ  
ᠠᠶᠠᠴᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠨ

Үсгийн галиг:

1. p a ᠴ W R N Q L m š i
2. Y T B š i Y W L yarat[t]i
3. b i t g g b i l (g a) p a
4. b t d m

Үгийн галиг:

1. apa ᠴurun qalmiši
2. yat baši yol yarat[īt]i
3. bitigig bil(gä) apa
4. bitidim

Үгчилсэн орчуулга:

1. Апа чурын үлдээсэн
2. харийн толгойлогч (-оор) зам байгуулуулав
3. Бичгийг Бил(гэ) апа
4. бичив би.

Дөрвөн мөрөөр эмх цэгц муутай бичсэн энэхүү бичээст харь улс, овог аймгийн цэргийн олзлогдсон захирагч, удирдагчаар удирдуулж, магадгүй түүний захиргаанд байсан тэдний олзны цэргүүдээр зам засуулсан үйл явдлыг тэмдэглэн үлдээсэн бололтой байна. Олзны захирагч, цэрэг ардаар зам, өртөө

зам байгуулах ажлыг ерөнхийд нь Билгэ апа чур хариуцаж, тэдний захирагч байсан бололтой. Бичээсийн төгсгөлөөс үзвэл, Билгэ апа чур бичээсийг бичсэн, Апа чурын бүрэн өргөмж цол нь Билгэ апа чур мөн ажээ. Зам, өртөө байгуулах ажлыг гүйцэтгэж, өгсөн үүрэг даалгаврыг амжилттай биелүүлсэн Билгэ апа чур Наран толгойд тахил өргөж энэхүү бичээсийг бичсэн байх магадлалтай. Зам байгуулах гэдгийг эдүгээчилж хэт явцуу утгаар ойлгож огт болохгүй бөгөөд үүнд замын чиглэлийг тогтоох, дайран өнгөрөх өртөө буудал, харуулын цамхаг, шалгах суурин, харуул манаа байрлах байр сууц барьж байгуулах, худаг ус гаргах ажил ч бас багтана. Уйгур улсын нийслэл Орду балык буюу өдгөөх Хар балгас хүрэх гол, төв замыг үүгээр буюу Нар толгойн өмнүүр Зүйлийн хөндийгөөр дайрч өнгөрч байхаар тогтоож, замын аюулгүй байдлыг сахих, гадаад, дотоодоос ирэгсдийг шалгах харуул манаа суулгах байр суурин байгуулсан түүхэн үйл явдлыг энэхүү бичээст тэмдэглэн үлдээсэн байж болох юм.

Наран толгойд сэргийлэх харуул манаа суулгаж байснаас харуулын захирагч, ноёд энд тэнд байх хэсэг бусад бичээсийг үлдээсэн нь лавтай бөгөөд тэдний байрлаж байсан харуул манааны цамхаг, бэхлэлт суурин ойр орчимд байх боломжтой учир дурдагдаж буй мэдээ баримтыг шалгах үүднээс Наран толгой орчим, Зүйлийн хөндийд эртний, бэхлэлт суурины буйр суурь байгаа эсэхийг археологийн хайгуул судалгаагаар тодруулах зайлшгүй шаардлагатай. Хэрвээ Уйгурын үеийн бэхлэлт суурины үлдэл, буйр суурь илрэх аваас түүхэн чухал баримт болох нь гарцаагүй.

### Зургаадугаар бичээс

Тавдугаар бичээсийн хоёрдугаар мөрийн доод талд, доороос дээш чиглэлтэй бичсэн хоёр үсэг тэмдэгт байх тул зургаадугаар бичээс гэв.

Хэрвээ бичээс гэж үзвэл, уг бичээсийг тавдугаар бичээс бичсэн цаг хугацаанаас хожим бичсэн болох нь илт байна. Дахин нягтлан шалгах шаардлагатайг онцлон тэмдэглэе (Зураг 6).

#### Хүснэгт 6. Наран толгойн VI бичээсийн уншлага

Эхийн сийрүүлэг: ДН

Үсгийн галиг: Q Y

Үгийн галиг: qaya

Үгчилсэн орчуулга: хад, чулуу.

Монголын руни бичгийн бага дурсгалд ᠳᠠᠨᠠᠭᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠨ yalim qaya буюу хад, чулуу, толигор хад гэсэн үгс цөөнгүй тохиолдох ба зарим бичээст ДН qay гэж төгсгөлийн а үсгийг орхигдуулсан нь буй.

Төв аймгийн Заамар сумын Улаан чулуутын дөрөвдүгээр бичээст  $\text{I} \gg \text{Y} : \text{Z} \text{D} \text{H} \gg \text{J} \text{D} : \text{N} : \text{Q} \gg : \text{X}$   $\text{Y} \text{Z} : \text{H} \text{J} \text{L} \text{J} \text{D} \text{H}$  yärdä: uluyi: yalim qaya: ärmis - газар дайдад их (элбэг) нь толигор хад ажээ (Баттулга 2022: 219-225) хэмээснээс  $\text{J} \text{D} \text{H}$  qaya хад чулуу гэх үгийн хэрэглээ өргөн байсныг харж болно.

### Долоодугаар бичээс

Наран толгойн овооны баруун өмнө талын босоо, бор хүрэн хаданд дөрвөн үсэг тэмдэгт бүхий нэг мөр бичээс байна. Бичээст шууд болон дам холбогдох тамгагүй. Үсэг тэмдэгтийн өндөр 4 см, мөрийн урт 30 см. Наран толгойн овооны баруун доод талын цуварсан босоо, хүрэн бор хаданд хадны өнгөн хэсгийг холцруулах аргаар, гүнзгий бус, ором мөр гаргах төдий цохиж бичжээ (Зураг 7).

Хаданд холцруулан цохих аргаар бичсэн ганц дурсгал гэдгээрээ Наран толгойн бусад руни бичгийн дурсгалуудаас ялгарч байна.



Зураг 6. Тав болон зургаадугаар бичээс

гэж бичсэн нь бичээс бичигч этгээд хавраас намар хүртэл гурван улирал дараалан энд суусан, байснаа тэмдэглэн үлдээхийг зорьсон уу, эсвэл уран сэтгэлгээ, хийсвэрлэл тэмдэглэл үү гэдгийг мэдэх боломжгүй.

### Наймдугаар бичээс

Наран толгойн овооны өмнө талд, хоёр хажуу талаасаа эмтэрсэн бор саарал хаданд хоёр мөр бичээс сийлжээ. Бичээсийг хурц үзүүртэй багажаар өнгөцхөн зурж бичсэнээс он цагийн уртад ихэд балархайшжээ.

Бичээсийн нэгдүгээр мөрийн урт 36 см, үсгийн өндөр 6-5 см, хоёрдугаар мөрийн урт 16 см, үсгийн 5 см. Бичээсийн баруун дээд буланд хоёрдугаар мөрийг, түүний доор хадны баруун талд нэгдүгээр бичээсийг бичжээ. Бичээч бичээсийн үсэг тэмдэгтийг тооцоогүйгээс эхний мөрийг бичээд үргэлжлүүлэх

### Хүснэгт 7. Наран толгойн VII бичээсийн уншлага

|                    |                                       |
|--------------------|---------------------------------------|
| Эхийн сийрүүлгэ:   | $\text{H}[\text{H}]\text{H} \text{D}$ |
| Үсгийн галиг:      | Y z k [ü] z                           |
| Үгийн галиг:       | yaz küz                               |
| Үгчилсэн орчуулга: | хавар, намар                          |

Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудаас Күл тигиний гэрэлт хөшөөний хойд талын 8-р мөр, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 31-32-р мөр, мөн өмнө талын 3-р мөрд тус тус нэг удаа  $\text{H} \text{D}$  yaz – хавар гэх үг, Уйгурын үеийн руни бичгийн сонгодог дурсгалуудаас Могойн шинэ усны буюу Моюн чурын гэрэлт хөшөөний зүүн талын 8-р мөрд  $\text{H} \text{H} \text{H}$  küz- намар гэж ганц удаа тохиолдоно. Монголын руни бичгийн дурсгалд жилийн дөрвөн улирлын нэр тун цөөн тэмдэглэгдсэн болохыг дээрх баримт харуулж байна. Бичээст  $\text{H} \text{H} \text{H}$  küz гэх үгийн  $\text{H}$  ü үсгийг сэргээсэн тул дөрвөлжин  $\text{H}$  хаалтад бичив.

Наран толгойн энэхүү бичээст хавар, намар



боломжгүй болсонд уг мөрийн дээд талд төгсгөлийн мөрийг бичсэн бололтой.

Олон дахин нягталсны эцэст, дээрх хоёр мөрийн өмнө, хойно үсэг тэмдэгт болон үг байхгүй байна гэж үзэв. Гэхдээ дахин нарийн нягт шалгах шаардлагатайг тэмдэглэе (Зураг 8).

### Хүснэгт 8. Наран толгойн VIII бичээсийн уншлага

|                    |                                                                                 |
|--------------------|---------------------------------------------------------------------------------|
| Эхийн сийрүүлгэ:   | $\text{H} \text{H} \text{H} \text{Y}$ 1.<br>$\text{I} \gg \text{H} \text{H}$ 2. |
| Үсгийн галиг:      | 1. r t η ü<br>2. s t i m s                                                      |
| Үгийн галиг:       | 1. ärtiηü<br>2. äšit[t]imiš                                                     |
| Үгчилсэн орчуулга: | 1. Гүн хүндэтгэлтэйгээр<br>2. сонсгожээ                                         |



Зураг 7. Долоодугаар бичээс

Тус бичээст **ᠮᠠᠨᠠ** ᠠᠷᠲᠢᠨᠢ гүн хүндэтгэлтэйгээр гэж тэмдэглэсэнд тулгуурлавал, хаан эсвэл хан зэрэг эрх мэдэлт, өндөр дээд албан тушаалтнаас ирсэн зарлиг, тушаалыг уншиж сонсгосон үйл явдалд зориулж бичжээ хэмээн үзэж болохоор байна. Тэрхүү “*гүн хүндэтгэлтэйгээр сонсгосон*” мэдээ нь баяр бахдал төрүүлэхүйц сайхан мэдээ, хөхиүлсэн чимээ сураг, захидал зарлиг байснаас хаданд тэмдэглэн бичиж үлдээсэн нь эргэлзээгүй.

### Есдүгээр бичээс

Наран толгойн өмнө энгэрт, баруун хойд зүг харсан байрлалтай, 35 см х 35 см толигор хүрэн бор хадны доод буланд ирмэгдүүлэн хоёр хэсэг бичээс цувруулан бичжээ.

Анх илрүүлсэн хоёр бичээсийн нэг мөн бөгөөд Яглахар овог аймгийн нэг тамгыг маш тод сийлсэн байна. Бичээсийн нэгдүгээр мөрийн урт 10 см, үсгийн өндөр 3 см, хоёрдугаар мөрийн урт 10 см,

үсгийн өндөр 3-5 см. Нэгдүгээр мөр арван нэгэн үсэг тэмдэгтээс, хоёрдугаар мөр үг зааглах нэг хос цэг, есөн үсэг тэмдэгтээс тус тус бүрдэж байна (Зураг 9).

*Хүснэгт 9. Наран толгойн IX бичээсийн уншлага*

Эхийн сийрүүлгэ: **ᠡᠭᠡᠨᠢᠯᠦᠰᠤᠨ**.1

ጽሑፍ: 1. ሰነድ .2

Үсгийн галиг: 1. d i č W R G b i t i g m

2. k ü č i : b i t g m

Үгийн галиг: 1. ädi (~idi) čuruy bitigim

2. küči: bitigim

Үгчилсэн орчуулга: 1. Эзэн чур миний бичиг

## 2. Күчи миний бичиг

Тус бичээсийн 人 ё үсгийг бусад үсэгтэй харьцуулахад маш бүдэг сийлжээ. Харин 𐎢𐎠𐎫𐎡𐎴 𐎢𐎡𐎴 үгийн төгсгөлийн 𐎢 үсэг хадны бондгор ургац таарснаас тийн бичсэн үү, эсвэл тусгаарлах : хос тэмдэг үү гэдгийг нягтлууштай.

Бичээст шууд холбогдох тамга Яглахар (4444)



Зураг 8. Наймдугаар бичээс

уулаага) овгийнх тул “Эзэн чур” хэмээгч Яглахар овгийн язгууртан болох нь лавтай. Өөрөөр хэлбэл, Яглахарын холбооны цөм бүрдэлдэхүүнд багтах, эрх мэдэл, хүч чадалт, бичээст шууд холбогдох дээрх тамга бүхий овог аймгийн эзэн захирагч нь чур цолтой,  $\Lambda\text{H}$  күс Хүч гэх нэртэй нэгэн байжээ хэмээн үзэж болох юм.

“Эзэн чур миний бичиг” гэж үлдээсэн тохиолдолд хэн гэгч чурын үлдээсэн бичиг болох, мөн аль овог аймгийн чур гэдэг нь тодорхойгүй болох тул Күчи чур өөрийн нэр, эрх мэдэл, цолоо дурдаж, овог аймгийнхаа тамгыг үлдээсэн бололтой.

Өөрөөр хэлбэл, Уйгур улсын төрийг захирагч хааны овгийнх гэдгээрээ бахархдаг язгууртан Күчи энэхүү бичээс, тамгыг сийлжээ.

Эл бичээсийн тамганы өмнө маш тод, гүнзгий сийлсэн  $h$   $t$  үсэг тэмдэгт байх боловч үргэлжлүүлж бичээгүй байна. Бичээсийн эндээс эхлүүлж бичихийг завдсан ч хэт бага зай талбай үлдсэнээс бичилгүй орхисон байж болох юм. Монголын руни бичгийн дурсгалд түгээмэл тохиодох  $\text{H}\text{H}\text{H}$   $t\text{H}\text{H}$  тэнгэр гэх үгээр эхлэх бичээс бичих байсан ч хадны доод талд шинээр бичихдээ өмнөх агуулгаа магадгүй өөрчилж бичсэн байх талтай.

Тамганы бүтцийг задалбал  $\Lambda$   $ata$ - эцэг дээдэс гэсэн утга бүхий үсэг тэмдэгт дээр Яглахар овгийн тамгыг байрлуулжээ гэж үзэж болох тул тамганы утга бэлгэдэл нь эцэг Яглахар буюу Яглахар эцгийн,


овгийн аймаг гэсэн утга агуулж буй бололтой хэмээн таамаглаж байна. Тамга бүр тодорхой утга, бэлгэдэл агуулсан дүрс, тэмдэг, тэмдэглэгээ тул дүрсийг тэмдэглэн буулгахаас гадна тамганы утга бэлгэдлийг ухаж ойлгох, судлах шаардлагатайг далимд тэмдэглэе.

### Аравдугаар бичээс

Яглахар овог аймагт холбогдох маш тод сийлсэн тамга дагалдуулж  $\Lambda$   $p$  гэх үсэг тэмдэгт бичжээ. Үсэг тэмдэгтийн өндөр 11 см. Энэхүү тамга, үсэг тэмдэгтийг орхигдуулахгүйн тулд бид аравдугаар бичээс хэмээн тэмдэглэв (Зураг 10).

Харин тамгын дүрсийг  $\Lambda$   $\checkmark$  болон  $\text{H}$   $g$  гэх хоёр үсэг тэмдэгтийн нийлбэр гэж задлан үзэж болно. Өөрөөр хэлбэл,  $\Lambda$   $i\checkmark$  нь дотор, дотоод,  $\text{H}$   $g$  нь эр, цэрэг, эр цэрэг, цэрэг дайчин гэсэн утгатай. Энэ тохиолдолд, уг дүрс бүхий тамгын бэлгэдэл утга нь дотоод цэргийн эвсэл, нэгдэл буюу Яглахар тэргүүт овог аймгийн нэгдэл, эвсэл гэсэн утга бэлгэдэл бүхий байх боломжтой. Дангаараа  $\text{H}\text{H}$   $g$  гэж байсан бол хөөж, довтолж гэсэн утгатай үг хэмээн үзэж болох байв.

Э.Саранболор, Г.Батболд нар Өвөрхангай аймгийн Хархорин сумын Цагаан голын Бага хүрхрээний ганц  $\text{H}$  үсэг тэмдэгтийг  $\text{H}$   $g$  эр, цэрэг гэж, мөн Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын Хүрмэн мухрын  $\text{H}$   $i$  хоёр үсэг тэмдэгтийн  $s\checkmark$  цэрэг, цэргүүд гэж тус тус уншсан (Саранболор, Батболд 2024: 116) нь нэг, хоёр үсэг



Зураг 9. Есдүгээр бичээс

тэмдэгтийг үл тоож орхих бус харин ч утга учрыг тайлах, судлах хэрэгтэйг харуулж байна. Ганц, хоёр үсэг тэмдэгтийг дээрх мэт уншиж судлалгүй орхигдуулсан цөөнгүй бий. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутагт орших Бигэрийн 7-р бичээст  $\text{Hl sQ}$  гэх хоёр үсэг тэмдэгтийг маш тод сийлснийг  $\text{Hl saq}$  болгоомжтой, сэрэмжтэй гэж унших боломжтой юм. Цаашид ганц хоёр үсэг тэмдэгт, тамга зэргийг үл тоож үлдээх бус тодорхойлж баримтжуулах нь үсэг бичиг, тамга судлалд чухал ач холбогдолтой эх хэрэглэгдэхүүн болохыг онцлон тэмдэглэе.

### Бусад бичгийн дурсгал болон тамга

Наран толгойд руни бичгийн дурсгалаас гадна нэлээд хожуу үед холбогдох монгол, төвд бичээс цөөн боловч байх ажээ. Бид энэ удаад, руни бичгийн дурсгалыг судалгааг чухалчилсан тул монгол, төвд бичээсийг тухайлан авч үзсэнгүй, харин монгол, төвд




Зураг 10. Аравдугаар бичээс

бичээс бас буйг мэдээлэх үүднээс цухас дурдав.

**Монгол бичээс.** Наран толгойн овооны зүүн өмнө байрлах, оройн хэсгээрээ зассан мэт дугуйрсан тогтоц бүхий хаданд уран, нарийн хийцтэй сийлсэн  $\text{öljei qutuγ orušiqu boltuγai}$  хэмээн дөрвөн мөрөөр бичсэн маш тодорхой монгол бичээс онцгой харагдана. Нэжгээд монгол бичээс байх боловч ихэвчлэн маани давамгайлж байна.

**Төвд бичээс.** Наран толгойд нийтдээ тав орчим төвд бичээс байх бөгөөд мөн л маани, тарни бичжээ.

**Тамга.** Наран толгойн хаданд түүхийн олон үед тамга байх бөгөөд тэдгээрээс Уйгурын Яглахар овгийн тамга зонхилж байна. Курлук, Басмил нарын тамга ч цөөнгүй байх бөгөөд бид тамганы дурсгалын бүртгэл судалгааг нэгтгэн хэвлүүлэх болно. Үүний учир, энэхүү өгүүлэлд тамганы тухайд цухас дурдав.



### Дүгнэлт

Наран толгойн руни бичгийн дурсгалууд үсэг зүйн хувьд эр, эм гийгүүлэгч хольж хутгасан хийгээд буруу, зөрүү харуулж бичсэн бичээс байхгүй, мөн өвөрмөц, онцлог үсэг тэмдэгтгүй, сонгодог бичгийн тиг хэлбэр бүхий тогтсон, чадварлаг бичлэгтэй бөгөөд бичээсийг бичиж үлдээгсэд, бичээч нар дадлага туршлагатай, бичиг эрдмийн чадвартан байсан нь илэрхий байна.

Руни бичгийн эдгээр дурсгалуудын байрлал энд тэнд, хад чулууны сонголт харилцан адилгүй байгаа нь нэг дор үйлдээгүйг, мөн өглөө, өдрийн өөр өөр цагт бичсэн болохыг нарны тусгалаас хамаарч бичээс тод, бүдэг харагдах байдлаас мэдэж болно.

Наран толгойн руни бичгийн дурсгалаас хоёр

бичээс тамгатай байгаагаас үзэхэд, бичээс дагалдуулж дурдатгагч, бичигч нар овог аймгийнхаа тамгаа сийлэхийг чухалчлаагүй бололтой. Дангаар цохиж, сийлж үлдээсэн тамга ч харьцангуй цөөн ажээ. Яглахар овгийн тамга Наран толгойн оройд, Басмил овгийн тамга толгойн баруун, харин Карлук нарын тамга толгойн зүүн талд төвлөрсөн байрлалтай байгаагаас тэдгээр овог аймгуудын эрх мэдэл, нийгэмд эзлэх байр суурийг мэдэж болохоор байна. Уйгурын хаант улсын төрийг Яглахар овгийнхон захирч байх үед эдгээр дурсгалыг тамгыг үлдээсэн болох нь тамганы байрлалаас илт анзаарагдаж байна. Түүнчлэн үсэг бичгийн тиг хэлбэр, үгийн санд тулгуурлан эдгээр бичээсийг он цагийн хувьд Уйгурын хаант улсын эхэн дунд үед холбогдоно хэмээн үзэж байна.

Хэдийгээр Уйгурын үед холбогдох боловч бүгд нэг дор бичигдсэн бус, өөр өөр жил, сар, өдөр болсон үйл явдлыг тэмдэглэсний зэрэгцээ ялангуяа бичээс бүрийн агуулга давтагдаагүйгээрээ онцлогтой юм.

Наран толгой нь Уйгурын үед Орхоны хөндийгөөс элсэн говийг уртрагийн дагуу чиглэсэн их замын хөвөөнд орших тахил тайлга хийдэг, аян замын ерөөл өргөдөг, хуран чуулах тэмдэглэлт чухал газар байсан байж болно.

Уйгур улсын нийслэлд хүрэх гол, төв зам Наран толгойн өмнүүр Зүйлийн хөндийгөөр дайрч өнгөрч байхаар тогтоож, замын аюулгүй байдлыг сахих, гадаад, дотоодоос ирэгсдийг шалгах харуул манаа суулгаж байснаас харуулын захирагч, ноёд энд тэнд байх хэсэг бусаг бичээсийг үлдээсэн байж болох юм. Энэ бүс нутагт эртний, бэхлэлт суурины буйр суурь байгаа эсэхийг археологийн хайгуул судалгаагаар тодруулах шаардлагатайг тэмдэглэе.

## Abstract

### Newly discovered runic inscriptions at Naran Tolgoi

**Tsend Battulga, Damchaabadgar Sodnomjamts,  
Tumurbaatar Tuvshinjargal**

In recent years, a detailed record of Mongolian runic monuments has emerged, allowing scholarship on the topic to become deeper and more detailed while it is still newly discovered. Here, we present the results of a preliminary study of the 10 runic inscriptions newly discovered from the Naran Tolgoi, in Yesunzuil soum, Uvurkhangai amag. Based on the shape of the alphabet and the vocabulary, it is believed that these inscriptions belong to the first half of the Uyghur Khaganate (744-840 AD). The inscription includes a memorial dedication to the to a sister that has passed on, describes tribal meetings, receipt of orders, construction of a postal road, and mention of ancestors and clans. In addition, the inscription indicates that the mountain of Naran Tolgoi (Khairkhan) was revered at that time as “Holy land and water” and makes reference to a political and military unit known as the flag-bearers (тугчин in Mongolian) during the Uyghur Khaganate, making this new find an important historical source.

**Keywords:** Runic script, Tamga (seal), Uyghur, Naran Tolgoi, Yesunzuil soum, Uvurkhangai aimag

## Ном зүй

Баттулга, Ц. (2022). Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа: Vol. II: Монголын төв, умард бүс нутаг дахь

руни бичгийн дурсгал. УБ.

Баттулга, Ц. (2024). Тэвш (Тэгш) уулнаас илрүүлсэн руни бичгийн хоёр шинэ дурсгал. Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol.13(1): 109-115.

Баттулга, Ц., Буян-Орших, Б. (2024). Тэвшийн уулын бичээсүүд. Studia Archaeologica, Tom. XLIV, Fasc. 13: 168-174.

Болд, Л. (1990). Тэвшийн бичээс. БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. УБ: 110-112.

Jens Wilkens. (2021). Handwörterbuch des Altuigurischen. Altuigurisch - Deutsch – Türkisch. Herausgegeben von der Akademie der Wissenschaften zu Göttingen. Universitätsverlag Göttingen: 574.

Наваан, Д. (1991). Археологийн экспедицийн тайлан. УБ.

Наделяев, В.М. (1974). Древнетюркская надпись из Ховд сомона МНР. In Бронзовой и железный век Сибири, Ленинград: 136-150.

Пэрлээ, Х. (2012). Өвөрхангайгаас олдсон хадны тамган дүрс зураг. (Археологийн тэмдэглэл). Х.Пэрлээ. Бүтээлийн чуулган. Боть IV. УБ: 191-194.

Окладников, А.П (1980), Петроглифы Центральной Азии. Кобд-Сомон (Гора Тэбиш). Ленинград.

Rintchen (1968), Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc. 1, УБ (Oulan bator).

Санжмятав, Т. (1995). Монголын хадны зураг. ШУА, Түүхийн хүрээлэн. УБ.

Саранболор, Э., Батболд, Г. (2024). Өвөрхангай аймгийн нутгаас шинээр илрүүлсэн хоёр бичээс, тамга. Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol. 13 (1): 116-122

Cleaves F.W (1955) Aldar cav ~ cav aldar. Harvard Journal of Asiatic Studies. Tom. 1, 2 (№ 18): 221-234.

Сэр-Оджав, Н. (1977) Монголын эртний түүх. УБ: 141.

Сэр-Оджав, Н. (1987). Монголын Археологи. Studia Archaeologica, Tom XII, Fasc.1: 10.

Харжаубай, С. (1979) Эртний гурван бичээс. Studia Archaeologica, Tom.VII, Fasc.12: 33.

*Received: Oct. 2, 2024; Revised: Nov. 10, 2024; Accepted: Dec. 16, 2024*

